



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 1/94

Баянхутаг сум

АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэн хийгдсэн үндэсний хөгжмийн зэмсэгийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Наранбадрал – Засаг даргын орлогч

Гишүүд: О.Цэрэннадмид – Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Д.Алтанчимэг – 2-р багийн засаг дарга

Л.Мөнхцогт – Соёлын төвийн хөгжмийн багш

Ц.Цэрэннадмид – Соёлын төвийн өвийн ажилтан.

2. Тус хөрөнгийн үзүүлэлтийг тодорхойлолтод заасны дагуу гүйцэтгэсэн эсэхэд хяналт тавин хүлээж авахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

3. Ажил хүлээлцсэн акт, гүйцэтгэлийн тайлан зэрэг холбогдох бусад бичиг баримтыг үндэслэн тус төслийн санхүүжилтийг олгохыг нягтлан бодогч (Х.Энхцэцэг)-т үүрэг болгосугай.

4. Соёлын төвд хүлээн авсан үндэсний хөгжмийн зэмсгийг үндсэн хөрөнгөд бүртгэж авахыг нягтлан бодогч (Х.Энхцэцэг), Нярав (Ц.Цэрэннадмид) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЙГАЛМАА



232501075